

**Н.ГАНТУЛГА**

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор, хурандаа

/Холбоо барих хаяг:
gantulga.n@leu.gov.mn
 Тел: 976-70155009/

**Н.БАТДОРЖ**

ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн ахлах багш, хошууч

МОНГОЛ УЛСАД ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДИЙГ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Илтгэлийн товч агуулга

Хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх ажиллагааны эрх зүйн өнөөгийн орчин, практикийн зарим асуудлыг хөндөн, судлаачийн дүгнэлт, саналыг илэрхийлэв.

Түлхүүр үг

Хорих ял эдлэгсэд /ялтан/, нийгэмшүүлэх ажиллагаа, хорих байгууллагын нийгмийн ажил, сэтгэлгээ, хамтын ажиллагаа, цогц арга хэмжээ зэрэг.

Илтгэлийн бүтэцУдиртгал

1. Хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх ажиллагааны эрх зүйн өнөөгийн орчин

2. Хорих байгууллагын нийгмийн ажилд тулгарч буй зарим хүндрэлүүд
 Дүгнэлт, санал

УДИРТГАЛ

Монгол улсын Үндсэн хуульд "... төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна..."² хэмээн хуульчилсан.

Мөн салбарын төрөлжсөн /органик/ хуулиудын түвшинд гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын үндсийг гэмт хэргийг урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ гэж тодорхойлсон³.

Статистикийн мэдээ, судалгааны бүтээлүүдээс үзвэл хорих ял эдлэгсэд, хорих байгууллагаас суллагдсан хүмүүсийн үйлдэж буй гэмт хэрэг, зөрчил тооны хувьд буурахгүй байгаа төдийгүй нийгмийн аюул занал, хор уршиг нь нэмэгдэж байна. Тухайлбал: 2014 онд манай орны хорих ангид 2048, цагдан хорих байранд 52, нийт 2100 зөрчил гарсан ба үүнийг 2013 онтой харьцуулахад:

- Алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлага эсэргүүцсэн, биелүүлээгүй зөрчил 36,6% /64/,

- Хориглосон тоглоом тоглосон зөрчил 47,7% /21/,

- Бусдын биед гэмтэл учруулсан зөрчил 64,3% /27/

- Бусад зөрчил 18,6% /78/ тус тус өссөн.

Харин согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчил 46,2% /61/, гар утас ашигласан зөрчил 9,2% /121/ буурсан, бусдыг дарамталж эд зүйл булаасан зөрчлийн тоон үзүүлэлт өөрчлөгдөөгүй байна.

² Төрийн мэдээлэл УБ.1992., №1 //19-р зүйлийн I дэхь хэсэг

³ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль //Төрийн мэдээлэл УБ.



Схем-1 Хорих байгууллагад ялтны үйлдсэн зөрчил, гэмт хэргийн байдал⁴

Мөн 2014 онд хорих ангид гарсан гэмт хэргийн⁵ тус бүр 5%-ийг хүний амь

⁴2015 оны 03-р сарын 05-06-нд зохион байгуулагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төв орон нутгийн удирдах ажилтны 2015 оны сургалт зөвлөгөөн”-д ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын даргын тавьсан мэдээллээс авав.

нас хохироосон, төрийн албан хаагчийг эсэргүүцэх, доромжлох, хулгайлах, 35%-ийг оргох, 50%-ийг бусдын биед гэмтэл учруулсан гэмт хэрэг бүрдүүлжээ.

Статистикийн сүүлийн 10 жилийн тоо баримтаас үзвэл манай орны хорих байгууллагаас жилд 500-600 гаруй ялтан суллагдаж, тэдгээрийн 40-45 орчим хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж байна⁶.

⁵ 2014 онд хорих ангид 20 гэмт хэрэг гарсан.

⁶ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төв орон нутгийн удирдах ажилтны 2015 оны сургалт зөвлөгөөн”-д ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын даргын тавьсан мэдээллээс авав.

Схем 2: Хорих байгууллагаас суллагдсан хүмүүсийн дахин гэмт хэрэг үйлдсэн байдал

Энэ байдлыг иш үндэс болгон “эрүүгийн хариуцлагын ... гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх

зүйлтэй холбон тайлбарладаг боловч хамгийн гол шалтгааны нэг нь ял эдлэгсэд, хорих байгууллагаас суллагдсан иргэдийн шаардлагын хэмжээнд хүрээгүй нийгэмшил /явцуу утгаараа “засрал хүмүүжил”/-ийн түвшин гэж судлаачийн зүгээс үздэг.



зорилго”⁷ хангалттай түвшинд хүрэхгүй байна гэсэн хэсэгчилсэн дүгнэлт хийж болно.

Яагаад энэ зорилго хангагдахгүй /хэрэгжихгүй/ байгаа болон түүний шалтгаан нөхцөл, нөлөөлж буй нийтлэг хүчин зүйлсийг бид улс орны эдийн засаг⁸, нийгэм⁹, хүн амын боловсрол, соёлын түвшин¹⁰, үзэгдэл, үйл явдалд хандах иргэдийн хандлагын өөрчлөлт, эрх зүйн орчны боловсронгуй бус байдал¹¹ зэрэг объектив, субъектив олон

Иймд ял эдлүүлэх салбарын судлаачийн хувьд олон улсын нийтлэг хэмжээ, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан ялтныг нийгэмшүүлэхтэй холбогдсон зарим дүгнэлт, саналыг өөрийн орны эрх зүйн орчин, практикт тулгуурлан хэлэлцүүлэхээр энэ илтгэлийг бичлээ.

I

Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд¹² “ялтныг нийгэмшүүлэх” гэсэн нэр томъёо тусгагдаагүй боловч түүний агуулгыг хэсэгчилэн илэрхийлсэн “ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх”¹³, “боловсролын сургалтанд хамруулж ...

⁷ МУ-ын Эрүүгийн хуулийн 45-р зүйлийн 45.3 //Төрийн мэдээлэл. УБ 2002 №05

⁸ Хүн амын цалин хөлс, амьжиргааны түвшин

⁹ Хавтгайрсан халамж, ажилгүйдэл, архидалт, чөлөөт шилжилт хөдөлгөөн зэрэг

¹⁰ Бүх шатанд эрх зүйг үгүйсгэх үзэл /нигилизм/ хүрээгээ тэлж ардчилал, анархизм /”дураар авирлах явдал”/зэрэгцэн оршиж тэдгээрийг иргэд ялгахад больсон.

¹¹ Эрх зүйн хийдэл, зөрчилдөөн, хяналт шалгалтын тогтолцооны доголдол зэрэг

¹² Манай улсад эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбогдсон харилцааг зохицуулсан энэхүү нэгдмэл хууль үйлчилдэг.//Төрийн мэдээлэл. УБ 2002 №08

¹³ Энэ хуулийн 8-р зүйлийн 8.2.3, 123-р зүйл, 124-р зүйл

мэдлэгээ дээшлүүлэхэд хорих анги туслалцаа үзүүлнэ”, “... ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулж болно¹⁴” гэсэн цөөнгүй зохицуулалт бий.

Мөн манай орны хорих байгууллагын тогтолцоонд нийгмийн ажлын эрх зүйн орчин, хууль зүйн практик олон улсын нийтлэг агуулга, хэлбэрийн хувьд зөвхөн 2003 оноос л бүрэлдэн төлөвшиж эхэлсэн¹⁵ гэх үндэслэлтэй баэрх зүйн орчны гол онцлог нь ялтныг нийгэмшүүлэх ажиллагааны агуулга-хэлбэрийг хуулийн дэд актуудын¹⁶ түвшинд “... ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, зан байдлыг засан төлөвшүүлэх, ялтанд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн дадал чадвартай болгох, ялтныг гэмт хэргийн хохирогчтой ойртуулах, эвлэрүүлэн зуучлах, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхэд хандуулах, ялтныг суллахад бэлтгэх...” гэж тодорхойлсон¹⁷.

Иймд манай орны хорих байгууллагын нийгмийн ажил “ялтны

бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд дэмжин туслах, хорих байгууллагаас суллагдсан үед тэднийг нийгэмд бие даан амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх” олон улсын нийтлэг зорилгыг чиг хандлага болгон хөгжиж байна гэх үндэслэлтэй.

Мөн өнөө үед манай оронд өрнөж буй эрх зүйн шинэтгэлийн үйл явцтай уялдуулан ялтныг нийгэмшүүлэх чиглэлээр явуулж буй төрийн бодлогын дараах онцлогыг дурьдаж байна. Энэ нь:

- Эрүүгийн ялын бодлогын тогтолцоон дахь хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх замаар хорих ялын эзлэх хувь хэмжээг, мөн хугацааг багасгах¹⁸,

- Хорих байгууллагын үйл ажиллагааг ялтныг “цэрлүүлэх” гэхээс илүү “нийгэмшүүлэх” бодлогод захируулах, хорих байгууллагыг “нээлттэй-хаалттай” тогтолцоонд шилжүүлэх, ял эдлэх орчин, ахуйг олон улсын жишигт ойртуулах, ялыг ялгамжтай эдлүүлэх бодит нөхцлийг бүрдүүлэх, ялтныг нийгэмшүүлэх ажиллагааг мэргэжлийн түвшинд зохион байгуулах¹⁹, ялтанд үзүүлэх урамшуулал,

¹⁴ Мөн хуулийн 125-р зүйл

¹⁵ ШШГЕГ-ын даргын 2004 оны 01-р сарын 23-ны өдрийн “Зарим албан хаагчдыг шилжүүлэн томилох тухай” Б/44-р тушаалаар тухайн үеийн хорих байгууллагын ахуй дэглэмийн байцаагчийн орон тоог “нийгмийн ажилтны орон тоо /албан тушаал/” болгон анхны 53 албан хаагчийг томилсон. Мөн ШШГЕГ-ын даргын 2006 оны 05-р сарын 08-ны өдрийн Б/250-р тушаалаар анх удаа сэтгэл зүйчийн албан тушаалд Г.Алтантуяа /Цагдан хорих 461-р ангид/ томилогджээ.

¹⁶ “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр” /ХЗДХ-ийн сайдын 2009 оны 10-р сарын 02-ны өдрийн 198-р тушаал/, “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /ХЗДХ-ийн сайдын 2009 оны 10-р сарын 14-ний өдрийн А/91-р тушаал/, “Хорих анги шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын байрны заавар” /ШШГЕГ-ын даргын 2010 оны 11-р сарын 10-ны А/107-р тушаал/, “Жишиг норматив тогтоох тухай” /ХЗДХ-ийн сайд, НХХ-ийн сайдын 2008 оны 08-р сарын 20-ны өдрийн 205/94-р хамтарсан тушаал/

¹⁷ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 198-р тушаал /“Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр”/

¹⁸ Өнөөдөр үйлчилж буй Эрүүгийн /2002 оны/ хуульд хорих ялын хугацаа 1-25 жил, цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд 30 жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солихг зохицуулалт бий. Харин хууль тогтоох байгууллагад энэ цаг үед хэлэлцэгдэж буй Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хорих ялын хугацааг 7 хоногоос 20 жил байхаар тусгажээ.

Манай орны шүүхийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн мэдээгээр нийт ялын дотор хорих ялын эзлэх хувь 2011 онд 77.4%, 2012 онд 77.6% байсан. Мөн хорих ял биечлэн эдлэгсдийн дундаж тоо 5000-5200-д хэлбэлзэж байсан бол 2012 оны байдлаар 8000 болж өссөн. //http: www.moj.gov.mn сайт дахь эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх танилцуулгаас авав.

¹⁹ Засгийн газраас санаачлан боловсруулж буй “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөлд энэ зохицуулалт орсон. //http: www.moj.gov.mn

шийтгэлийн тогтолцоонд “үр нөлөөг эрхэмлэх” зэрэг болно.

Судлаачийн үзэж байгаагаар манай орны хорих байгууллагуудад нийгмийн ажил зохих хэмжээнд явагдаж байгаа боловч түүний үргэлжлэл болсон хорихоос суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх ажиллагааны орчинд эрх зүйн хийдэл, зөрчилдөөн оршоор байна. Тухайлбал: өнөөг хүртэл хорихоос суллагдсан гэр оронгүй, ажлын байргүй, боловсрол, мэргэжилгүй хүмүүст нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх тогтвортой үйл ажиллагаатай тусгай байр, мэргэшсэн ажилтнууд байхгүй энэ ажил зөвхөн цөөн төрийн бус байгууллага, энэрэнгүй үйлст хувь хүмүүсийн идэвхи санаачилгад тулгуурлан явагдаж байна.

Мөн энэ дашрамд уг харилцааг хэсэгчлэн зохицуулсан зарим дэвшилтэт хэм хэмжээ²⁰ байдгийг зориуд тэмдэглэхийн сацуу гол асуудал нь энэ мэдээллийг иргэд /холбогдох хүмүүс/ сайн мэдэхгүй, нөгөө талаас түүний

²⁰ Тухайлбал:

• Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн:

-15-р зүйлийн 15.1.2-т “... хорих ангиас суллагдсан иргэнийг үйлдвэр дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар 1 жилээс доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, 1 жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг ажилтан, ажил олгогч тус бүрт 1 удаа олгох ...”

-15-р зүйлийн 15.1.5-д “... хорих газраас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачлага гаргасан, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж урамшуулна”²⁰

• Нийгмийн халамжийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.5-д “... онцгой тохиолдолд болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг ... хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэнд ... олгоно”²⁰ гэсэн.

хэрэгжилтэд хийсэн мониторингийн судалгааны дүн, статистикийн нэгдсэн тоо баримт улсын хэмжээнд алга байна.

II

Өнөөдөр манай орон 6600 гаруй хорих ял эдлэгсэдтэй ба ICPS байгууллагаас гаргасан 100 мянган хүн амд ноогдох ялтны тоогоор дэлхийд 44-рт эрэмбэлэгддэг²¹.

Хорих ял эдлэгсдийг дэглэм, хорих ангийн төрлөөр нь авч үзвэл 51.8% жирийн дэглэмд, 38.6% чанга дэглэмд, 4.6% онцгой дэглэмд, 1.2% гянданд, 1.1% эмэгтэйчүүдийн хорих ангид /жирд-80%, чангад-20%/, 0.4% насанд хүрээгүйчүүдийн хорих ангид /жирд-87%, чангад-13%/, 2.5% баривчлах ял эдлүүлэх газарт ял эдэлж байна.

Мөн хорих ял эдлэгсдийн 1.6% хөнгөн, 21% хүндэвтэр, 36.7% хүнд, 41.2% онц хүнд гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн²².

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2008 оны “Жишиг норматив тогтоох тухай” 205/94 хамтарсан тушаалд хорих ангийн төрөл, дэглэмтэй уялдуулан нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн ажиллах ялтны тоог ялгамжтайгаар тогтоосон боловч бодит байдалд олон хүчин зүйлсийн улмаас²³ энэ норматив

²¹ [https://ru.wikipedia.org/wiki/ICPS-Международный центр тюремных исследований](https://ru.wikipedia.org/wiki/ICPS-Международный_центр_тюремных_исследований); Монгол улсад ял эдэлж буй хүмүүсийн хүний эрхийн өнөөгийн байдал: судалгааны тайлан УБ. 2014, 13-14 дэх тал; 2015 оны 03-р сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төв орон нутгийн удирдах ажилтны 2015 оны сургалт зөвлөгөөн”-д ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын даргын тавьсан тайлан мэдээнээс авав.

²² Ц.Мөнхбат “Хорих байгууллагад үйлдсэн гэмт хэрэг зөрчлийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал” //Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл УБ. 2014 №4 (12), 21 дэх тал

²³ Өнөөдөр 1 нийгмийн ажилтанд дунджаар 90 гаруй ялтан ноогддог ба нийт нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн 60 гаруй хувь нь мэргэжлийн бус 21-35 насны эмэгтэй албан хаагчид ба тэдний дунд

тогтмол хэтэрч дээрх ажилтнууд ихээхэн ачаалалтай ажиллаж байна.

Мөн судалгааны баримтуудад тулгуурлан манай орны хорих байгууллагуудын нийгмийн ажилд дараах голлох хүндрэл бэрхшээл, дутагдлууд байна гэж үзлээ²⁴. Энэ нь:

1. Хорих ялыг ялгамжтай эдлүүлэх²⁵ орчин хангалттай бүрдээгүйн улмаас нэг дэглэмийн хорих ангид үйлдсэн гэмт хэргийн төрөл, тоо, засрал /төлөвшил/ хүмүүжлээр эрс ялгаатай ялтнууд хамтдаа ял эдэлж байгаа нь хорих байгууллагаас явуулж буй нийгмийн ажилд сөргөөр нөлөөлсөөр байна.

Тухайлбал, сүүлийн 5 жилийн статистикаас үзвэл сахилгын зөрчлийн учир дэглэм дээшилсэн ялтны тоо улам бүр нэмэгдэж²⁶, мөн онцгой дэглэмтэй хорих ангид онц аюултай гэмт хэрэгтэнтэй хамт бусад ялтан ял эдлэх практик өргөжиж байна²⁷.

2. Хорих байгууллагын нийгмийн ажлын төлөвшилтөд ял эдлүүлэх байгууллагын зохион байгуулалтын

хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн ихээхэн хийгддэг.

²⁴ ХСИС-ийн ШШГС-иас Хүний эрх, хөгжил төвтэй хамтран 2015 оны 01-р сараас 03-р сарын хооронд “Ялтны мэдээллийн эрэлт хэрэгцээг тодорхойлох” төсөлт ажлыг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд явуулсан анкет, фокус ярилцлага, ажиглалт, биечилсэн сурвалжлага зэрэг судалгааны тайлан болон бусад судалгааны материалд тулгуурлан энэхүү мэдээллийг бичиж байна. Тухайлбал, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2007 онд явуулсан “Хорих ялын үр нөлөө” судалгааны тайлан зэрэг.

²⁵ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийн 118-р зүйл.

²⁶ 2014 онд нийт ял эдлэгсдээс 0,04% нь /264 ялтан/ дэглэм дээшилсэн.

²⁷ Эрүүгийн хуулийн 52-р зүйлийн 57.7-д “2 ба түүнээс дээш удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтны хорих ялыг онцгой дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ”.

ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын 2015 оны 03-р сарын тайлан мэдээнээс үзвэл 2014 онд 264 ялтан дэглэм дээшилсэн, 691 ялтан дэглэм буурчээ.

бүтэц, албан хаагчдын орон тоо, ажил үүргийн хуваарилалт, дүгнэх үзүүлэлтийн оновчтой бус байдал²⁸, эрх зүйн хийдэл, зөрчилдөөн, нэгдмэл бус практик сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал:

-Боловсролын тухай хуулийн 6-р зүйлийн 6.3: “Монгол улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй”, 8-р зүйлийн 8.2: “Тодорхой хугацааны боловсролыг нөхөх, бие даан эзэмших зорилгоор бага, дунд боловсролыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр олгож болох бөгөөд уг хөтөлбөрийн агуулга, сургалт явуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийг газрын гишүүн батална” гэж хуульчилсан. Гэтэл бичиг үсэггүй /насанд хүрсэн/ хүнийг /ялтныг/ сургах, суурь боловсрол эзэмшүүлэх стандарт хөтөлбөрүүд, холбогдох журам боловсрогдон батлагдаагүйн улмаас энэ ажил улс орны хэмжээнд болон хорих байгууллагуудад харилцан адилгүй явагдаж байна.

-Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны “Жишиг норматив тогтоох тухай” 205/94-р хамтарсан тушаалд хорих байгууллагын сурган хүмүүжүүлэгчид ноогдох ялтны тоог ялгамжтай байдлаар тогтоон өгсөн²⁹ боловч ШШГЕГ-ын даргын тушаалаар “сурган хүмүүжүүлэгч”-ийн албан тушаалын орон тоо гагцхүү насанд хүрээгүйчүүдийн хорих ангид л бий болгон алба хаагчийг томилсон.

-“Хорих ангийн дотоод журам”-ыг шинэчлэн батласан хууль зүйн сайдын

²⁸ Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид хорих байгууллагын гүйцэтгэх ажил, харуул хамгаалалт эрхэлсэн дэд даргад харьяалагдан үйл ажиллагаа явуулдаг тул тэд цөөнгүй тохиолдолд үндсэн үүрэгтээ шууд хамааралгүй ажлыг /жишээ нь: эргүүлд гарах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх, ялтны байр орчинд цэвэрлэгээ хийлгэх зэрэг/ хийдэг.

²⁹ Нэг сурган хүмүүжүүлэгч төвлөрсөн хорих ангийн 75-150, гянданд 50-75 ялтантай тус тус ажиллах нормативтай.

2014 оны 12-р сарын 08-ны өдрийн А/230-р тушаалд: "... жирийн, чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа ялтан их, дээд сургууль, коллежид өөрийн зардлаар эчнээ хэлбэрээр суралцах..." харилцааг зохицуулсан боловч шаардлагатай орчин нөхцөл зохих түвшинд бүрдээгүйн улмаас хэрэгжилт³⁰ хангалтгүй байгаа, мөн журмын зарим зохицуулалтад судлаачийн хувьд шүүмжлэлттэй ханддагг³¹.

Түүнчлэн энэ журамд "... хорих ангийн цагийн хуваарьт ялтны зурагтын нэвтрүүлэг үзэх цагийг тодорхой тусган зохицуулахаар" журамласан боловч эрх зүйн хэм хэмжээний зөрчилдөөн, бусад хүчин зүйлсийн улмаас ялтнууд "өдрийн турш хязгаарлалтгүйгээр" зурагтын нэвтрүүлэг үзэх практик үргэлжилсээр байна.

Учир нь Хорих ангийн дотоод журмын 15-р зүйлийн 15.1-д "Хорих ангийн даргын баталсан цагийн хуваарийн дагуу ялтан хөдөлмөрлөх, амрах, хооллохоос бусад хугацааг чөлөөт цагт тооцно" гэж заасан тул харуул хамгаалалтын ажилтнууд ялтантай маргалдахгүй, үүсэн маргааныг хурцатгахаас сэрэмжлэн энэ асуудалд ач холбогдол өгөлгүй урсгалаар нь шийдвэрлэж байна.

ДҮГНЭЛТ

1. Манай оронд хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх ажиллагааны эрх зүйн орчин, практик олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдан бүрэлдэн төлөвшиж буй боловч түүний үр нөлөөг нэмэгдүүлэхэд судалгааны ажил, эрх зүйн орчин, практикийн нягт

уялдаа холбоо улам чухлаар тавигдаж байгааг нийгмийн бүх хүрээнд ойлгуулан ухамсарлуулах, хэрэгжүүлэх, энэ ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

2. Ялтныг нийгэмшүүлэх ажилд хууль тогтоомжийн шинэчлэлээс дутуугүй нийгэм, холбогдох субъектүүдийн хүсэл зориг, итгэл үнэмшил, дэмжлэг, сэтгэлгээний болон ажлын, арга барилын зэрэг хандлага, соёл, зөвшилцсөн хамтын ажиллагаа онцгой чухал байна.

3. Ялтныг нийгэмшүүлэх ажиллагааны манай эрх зүйн өнөөгийн зохицуулалтыг эрх зүйн дэд актаас хуулийн түвшинд гаргаж хорих байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгоход чиглэсэн эрх зүй, зохион байгуулалтын дэс дараатай арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай.

САНАЛ

Иймд дүгнэлттэй уядуулан дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

а/ Ялтны түр, удаан хугацааны уулзалт, тэдэнд олгох "чөлөө"-ний эрх зүйн зохицуулалтыг³² өргөжүүлэн шинэчлэх

б/ Ялтныг нийгэмшүүлэх ажлыг хорих байгууллагын төрөл, дэглэм, ял эдлэх нөхцөл, ялтны хувийн онцлог /нас, хүйс, зан төлөв, мэдлэг боловсролын түвшин зэрэг/-ийг харгалзан явуулах үлгэрчилсэн стандарт, жишиг хөтөлбөр, аргачлалыг бий болгон үр дүнтэй практикийг бүх талаар дэмжин урамшуулах, дэлгэрүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

в/ Ялтан, хорих байгууллагаас суллагдсан иргэдийг нийгэмшүүлэх /сурч боловсрох, хөдөлмөрлөх, аж амьдралд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх/-д оролцох

³⁰ 2013, 2014 онуудад тус бүр 5 ялтан их, дээд сургуульд суралцан төгсчээ.

³¹ Энэ журмын 15.3-т зааснаар: "их, дээд сургууль, коллежид суралцах хүсэлт гаргасан ялтан ... сахилгын зөрчил гаргаж байгаагүй... шаардлагыг хангасан үед хорих ангийн даргын саналыг үндэслэн ШШГЕГ-ын дарга суралцахыг зөвшөөрсөн тушаал гаргана".

³² Учир нь удаан хугацааны уулзалтыг түр уулзалтаар, мөн тэдгээрийг утсаар ярих боломжоор солих эрх зүйн орчин /119-р зүйл/ бүрдээгүйн зэрэгцээ чөлөөг зөвхөн баривчлах ял эдэлж буй болон жирийн дэглэмтэй хорих ангийн ялтанд л /107-р зүйл/ хамааруулан үзсэн.